



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2014 оны 08 сарын 06 өдөр

Дугаар 291

Улаанбаатар хот

┌ Даатгалын байгууллага болон даатгалын ┐
мэргэжлийн оролцогчид аудит хийх эрхийг
хүчингүй болгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.1.2, Даатгалын тухай хуулийн 14.1, 14.2.8, 33.2.2, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 20.2.2 дахь заалт, Хорооны 2010 оны 149 дүгээр тогтоолоор батлагдсан “Даатгалын байгууллагад аудит хийх үйл ажиллагааг зохицуулах журам”-ын 2.8, 2.10 дахь заалт, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институттай хамтран хийсэн даатгалын байгууллагын аудитын чанарын хяналтын үр дүнг үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Хорооны 2010 оны 149 дүгээр тогтоолоор батлагдсан “Даатгалын байгууллагад аудит хийх үйл ажиллагааг зохицуулах журам”-ын 2.9 дэх шаардлагыг биелүүлээгүй “Ситико-Аудит” ХХК-ийн даатгалын байгууллагад аудит хийх эрхийг хүчингүй болгосугай.

2. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д. БАЯРСАЙХАН

000303